

# Шагнал

Нэгэн байгууллага ажилтнуудаа шагнахаар шийджээ. Шагналаа өгөхдөө хөгжилтэй байдлаар өгөхөөр шийдсэн байна. Байгууллага  $n$  ажилтантай бөгөөд нэгэн ижил бэлэгнээс бүх ажилтандаа ялгаатай тоотой буюу 2-оос  $n+1$  ширхэгийг өгнө. Байгууллагын бүх ажилтнуудыг даргаасаа эхлэн 1-ээс  $n$  хүртэлх тоогоор дугаарлан тухайн дугаарт бүхлээр хуваагдахуйц тооны бэлэг өгөхөөр шийджээ. Бэлгийг ажилтнуудад хуваарилах нэг боломжийг ол.

Оролт:

Байгууллагын ажилтны тоо болох  $n$  бүхэл тоо. ( $1 \leq n \leq 10^6$ )

Гаралт:

Бэлэг хуваарилах хувилбарыг элементүүдийн хооронд сул зайгаар тусгаарлан гаргана. Олон боломжит хувилбар байвал аль нэгийг нь гаргана.

Жишээ

Оролт:

2

Гаралт:

3 2

Жич: Энэ бодлого 2011 онд Мэдээлэл зүйн улсын олимпиадад сурагчдын төрөлд ирж байсан.